



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК  
Захирал Г.Саранчимэг  
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com  
Аудитор: О.Мандах  
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага.....	17
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Ир эдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024. 2. 23 № 2/37  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн.

Тус сургуулийн захирлын “Албан хаагчдад урамшуулал олгох тухай” 2023 оны 12 сарын 28-ны өдрийн А/34 тоот тушаалаар алба хаагчдад цалингийн сангийн хэмнэлтээс 1 сарын үндсэн цалингийн урамшуулалд 24,207,819.00 төгрөг олгосон зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагад энэ хуулийн 44.5.1, 46.3 хамаарахгүй, Засгийн газрын ” 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.3, 4.5, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалын Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журмын 1.1, 1.4, Засгийн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, байгууллагын хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.3, 3.11 дэх заалтуудыг тус тус зөрчин дүнгийн урамшууллыг олгосон, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5020043

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 922,275.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 833,058,0 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 1,887.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 70,878.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

### **Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 90,2 хувьтай тайлагнасныг 81.9 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,639,802.31	142,311,048.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	80,029,739.63	70,878,416.61
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	80,029,739.63	70,878,416.61
31210	Төгрөг	80,029,739.63	70,878,416.61
31211	Төрийн сангийн харилцах	80,029,739.63	70,878,416.61
35	БАРАА МАТЕРИАЛ	64,610,062.68	71,432,631.93
35100	Түүхий эд материал	56,966,500.48	62,042,915.48
35110	Тусгай зориулалттай материал	56,966,500.48	62,042,915.48
35400	Хангамжийн материал	7,643,562.20	9,389,716.45
35420	Аж ахуйн материал	572,000.00	829,500.00
35470	Бусад хангамжийн материал	7,071,562.20	8,560,216.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,002,112,406.89	1,145,593,225.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,002,112,406.89	1,145,593,225.13
39200	Биет хөрөнгө	988,126,406.89	1,131,607,225.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,085,741,834.00	1,250,457,303.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-188,439,399.24	-235,513,837.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	145,685,180.37	137,259,876.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,194,609.45	-56,146,805.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,163,376.00	51,775,080.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,607,437.95	-32,653,016.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,790,700.00	18,790,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,697,675.04	-7,046,512.56
39217	Ном	4,684,438.20	4,684,438.20
39300	Биет бус хөрөнгө	13,986,000.00	13,986,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,986,000.00	13,986,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,146,752,209.20	1,287,904,273.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,146,752,209.20	1,287,904,273.67
51	Засгийн газрын хувь оролцоо	1,146,752,209.20	1,287,904,273.67
51100	Засгийн газрын оруулсан капитал	147,876,387.30	147,876,387.30
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	147,876,387.30	147,876,387.30
51200	Хуримтлагдсан үр дүн	374,543,806.42	516,455,685.89
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,039,023,383.99	375,303,621.42
51220	Тайлант үеийн үр дүн	1,413,567,190.41	141,152,064.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	624,332,015.48	623,572,200.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,146,752,209.20	1,287,904,273.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	763,215,862.2	1,011,098,838.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,077,362.2	187,057,938.25
120	Нийтлэг татварын бус орлого	21,077,362.2	187,057,938.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	935,200.00	1,752,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	935,200.00	1,752,900.00

**Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,916,600	183,477,969.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,225,562.2	1,827,069.25
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>742,138,500.00</b>	<b>824,040,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>627,809,600.00</b>	<b>707,973,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	627,809,600.00	707,973,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>114,328,900.00</b>	<b>116,067,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,328,900.00	116,067,500.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>728,093,708.28</b>	<b>869,946,773.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>728,093,708.28</b>	<b>869,946,773.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>673,965,269.28</b>	<b>835,809,695.12</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>402,417,039.10</b>	<b>545,000,727.22</b>
210101	Үндсэн цалин	299,261,107.00	393,548,245.23
210102	Нэмэгдэл	89,558,432.10	135,531,429.44
210104	Урамшуулал	5,762,304.00	15,921,052.55
210105	Гэрээт ажлын хөлс	7,835,196.00	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,570,292.99</b>	<b>64,371,895.80</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,697,359.38	42,911,862.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,808,391.27	5,386,463.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,217,211.29	4,309,250.74
210204	Ажилгүйдлийн даатгал	804,302.82	1,069,583.53
210205	Эрүүл мэндийн даатгал	8,043,028.23	10,694,735.26
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>86,018,365.00</b>	<b>109,180,421.34</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,471,485.00	8,456,242.14
210302	Түлш, халаалт	79,046,880.00	98,924,179.20
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,953,100.00</b>	<b>12,321,650.00</b>
210401	Бичиг хэрэг	3,446,765.00	6,445,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,126,835.00	1,250,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,410,300.00	4,625,350.00
210408	Бараа материал акталсны зардал	5,969,200.00	0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,899,450.00</b>	<b>32,350,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,326,400.00	138,250.00
210502	Хоол, хүнс	30,573,050.00	32,212,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	5,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,711,100.00</b>	<b>5,462,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	935,200.00	1,224,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,775,900.00	4,238,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>79,395,922.19</b>	<b>62,122,050.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,233,400.00	1,007,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,810,300.00	6,357,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,352,222.19	54,757,150.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,128,439.00</b>	<b>34,137,078.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,632,500.00</b>	<b>32,250,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,632,500.00	32,250,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>18,495,939.00</b>	<b>1,887,078.66</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,495,939.00	1,887,078.66
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>35,122,153.92</b>	<b>141,152,064.47</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-2,945,273.56</b>	<b>0</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,945,273.56	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>32,176,880.36</b>	<b>141,152,064.47</b>

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	743,073,700.00	825,793,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	935,200.00	1,752,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	935,200.00	1,752,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	935,200.00	1,752,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	935,200.00	1,612,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	742,138,500.00	824,040,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	627,809,600.00	707,973,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	627,809,600.00	707,973,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,328,900.00	116,067,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,328,900.00	116,067,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	651,088,960.37	820,185,123.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	651,088,960.37	820,185,123.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	596,960,521.37	786,048,044.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,417,039.10	545,000,727.22
210101	Үндсэн цалин	299,261,107.00	393,548,245.23
210102	Нэмэгдэл	89,558,432.10	135,531,429.44
210104	Урамшуулал	5,762,304.00	15,921,052.55
210105	Гэрээт ажлын хөлс	7,835,196.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,508,467.27	64,371,895.80
210201	Тэтгэврийн даатгал	37,085,619.65	42,911,862.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,355,710.39	5,386,463.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,684,568.22	4,309,250.74
210204	Ажилгүйдлийн даатгал	671,142.16	1,069,583.53
210205	Эрүүл мэндийн даатгал	6,711,426.85	10,694,735.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,018,365.00	109,180,421.34
210301	Гэрэл, цахилгаан	5,471,485.00	8,456,242.14
210302	Түлш, халаалт	79,046,880.00	98,924,179.20
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,800,000.00
2105	Нормативт зардал	30,573,050.00	32,212,000.00
210502	Хоол, хүнс	30,573,050.00	32,212,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,711,100.00	5,462,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	935,200.00	1,224,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,775,900.00	4,238,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,732,500.00	24,820,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,568,700.00	18,462,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,163,800.00	6,357,800.00

**Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,128,439.00	34,137,078.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,632,500.00	32,250,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,632,500.00	32,250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,495,939.00	1,887,078.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,495,939.00	1,887,078.66
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	91,984,739.63	5,608,676.98
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,955,000.00	14,760,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,955,000.00	14,760,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,955,000.00	14,760,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,955,000.00	14,760,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-11,955,000.00	-14,760,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	80,029,739.63	-9,151,323.02
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	80,029,739.63
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,029,739.63	70,878,416.61

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	302,762,041.46	1,097,168,362.06
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	302,762,041.46	1,097,168,362.06
9	Тайлант үеийн үр дүн	0	0	139,249,571.59	139,249,571.59
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	624,332,015.48	374,543,806.42	1,146,752,209.20
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	147,876,387.30	624,332,015.48	374,543,806.42	1,146,752,209.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	759,815.00	759,815.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	147,876,387.30	624,332,015.48	375,303,621.42	1,147,512,024.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-759,815.00	0	-759,815.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	141,152,064.47	141,152,064.47



**Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

20	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	147,876,387.30	623,572,200.48	516,455,685.89	1,287,904,273.67
----	--------------------------------------	----------------	----------------	----------------	------------------

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>906,750,500.0</b>	<b>833,058,044.36</b>	<b>73,692,455.64</b>	<b>91.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>906,750,500.0</b>	<b>833,058,044.36</b>	<b>73,692,455.64</b>	<b>91.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>868,306,800.0</b>	<b>800,808,044.36</b>	<b>67,498,755.64</b>	<b>92.2</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>595,864,400.00</b>	<b>545,000,727.22</b>	<b>50,863,672.8</b>	<b>91.5</b>
210101	Үндсэн цалин	417,984,400.00	393,548,245.23	24,436,154.8	94.2
210102	Нэмэгдэл	160,295,500.00	135,531,429.44	24,764,070.6	84.6
210104	Урамшуулал	17,584,500.00	15,921,052.55	1,663,447.5	90.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,483,200.00</b>	<b>64,371,895.80</b>	<b>10,111,304.2</b>	<b>86.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,648,500.00	42,911,862.85	7,736,637.2	84.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,958,700.00	5,386,463.42	572,236.6	90.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,766,900.00	4,309,250.74	457,649.3	90.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,191,800.00	1,069,583.53	122,216.5	89.7
210205	Эрүүл мэндийн даатгал	11,917,300.00	10,694,735.26	1,222,564.7	89.7
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>111,067,500.0</b>	<b>109,180,421.3</b>	<b>1,887,078.7</b>	<b>98.3</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,211,300.0	8,456,242.1	1,755,057.9	82.8
210302	Түлш, халаалт	99,056,200.0	98,924,179.2	132,020.8	99.9
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.0	1,800,000.0	0.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,533,200.00</b>	<b>32,212,000.00</b>	<b>3,321,200.0</b>	<b>90.7</b>
210502	Хоол, хүнс	35,533,200.00	32,212,000.00	3,321,200.0	90.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000,000.0</b>	<b>5,000,000.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	5,000,000.0	5,000,000.0	0.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,778,200.00</b>	<b>5,462,700.00</b>	<b>1,315,500.0</b>	<b>80.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,539,700.00	1,224,200.00	1,315,500.0	48.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,238,500.00	4,238,500.00	0.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,580,300.00</b>	<b>39,580,300.00</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,222,500.00	33,222,500.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,357,800.00	6,357,800.00	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,443,700.00</b>	<b>32,250,000.00</b>	<b>6,193,700.0</b>	<b>83.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,443,700.00</b>	<b>32,250,000.00</b>	<b>6,193,700.0</b>	<b>83.9</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,443,700.00	32,250,000.00	6,193,700.0	83.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>906,750,500.0</b>	<b>825,793,800.0</b>	<b>80,956,700.0</b>	<b>91.1</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>707,973,400.00</b>	<b>707,973,400.00</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	707,973,400.00	707,973,400.00	0.0	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>116,067,500.0</b>	<b>116,067,500.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	116,067,500.0	116,067,500.0	0.0	100.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>82,709,600.00</b>	<b>1,752,900.00</b>	<b>80,956,700.0</b>	<b>2.1</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,539,700.00	1,612,900.00	926,800.0	63.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	140,000.00	0.0	100.0

**Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	80,029,900.00	0	80,029,900.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	80,029,739.63	-80,029,739.6	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	70,878,416.61	-70,878,416.6	0.0
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>35.0</b>	<b>32.0</b>	<b>3.0</b>	<b>91.4</b>
620001	Удирдах ажилтан	2.0	2.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23.0	21.0	2.0	91.3
620003	Үйлчлэх ажилтан	10.0	9.0	1.0	90.0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>31.0</b>	<b>29.0</b>	<b>2.0</b>	<b>93.5</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	31.0	29.0	2.0	93.5

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Заг сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд “Сургалтын таатай орчинд боловсролын үйлчилгээг чанартай тэгш хүртээсэн хүүхдэд ээлтэй олон нийтийн оролцоот сургууль болоход оршино” эрхэм зорилго дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Үндсэн багш, Дотуур байр гэсэн бүтэц зохион байгуулалттай 32 орон тоотой, 273 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ө.Март, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч У.Сүхбаатар нар зурж, нярваар Б. Баасанбат нар ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;

- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 141,152.1 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	80,029.70	70,878.40	-9,151.30
Авлага	0	-	0)
Бараа материал	64,610.10	71,432.60	6,822.50
Үндсэн хөрөнгө	1,328,051.50	1,476,953.40	148,901.90
хуримтлагдсан элэгдэл	-325,939.10	-331,360.20	-5,421.10
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,146,752.20</b>	<b>1,287,904.30</b>	<b>141,152.10</b>

Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,146,752.20	1,287,904.30	141,152.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,146,752.20	1,287,904.30	141,152.10

Эх сурвалж: Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 80,029.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 70,878.4 мянган төгрөгийн өмнөх оноос 9,151.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл 6,822.5 мянган төгрөгөөр өмнөх оноос бараа материал өссөн байгаа нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 86,917.4 мянган төгрөг, Боловсролын ерөнхий газраас 1,827.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй авч үйл ажиллагаанд 81,921.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд авлага, өр төлбөр байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 148,901.9 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн нь төсвийн хөрөнгөөр 14,760.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. Заг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/174 дүгээр тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн барилгын урсгал засвар, сургуулийн дотуур байрны засварт 79,001.1 мянга, хичээлийн байранд 49,500.9 мянга, спорт зааланд 36,214.4 мянган төгрөг нийт 164,715.5 мянган төгрөгийн хөрөнгө, Боловсролын ерөнхий газраас хөрөнгө оруулалтаар 18,762.5 мянган төгрөгийн хөрөнгө нийт 198,238.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.10.11-ны өдрийн 16/49 тогтоолоор 49,336.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж хөрөнгийн данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 141,152.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,287,904.3 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 141,152.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 287,904.3 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 671,534.2 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 671,534.2 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 107,633.2 мянган төгрөгөөр буурч 563,801.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 707,973.4 мянган төгрөг болгож 144,172.4 мянган төгрөгөөр

нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 707,973.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урьд оны үлдэгдлээс санхүүжих 80,029.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2679.7 мянга, орон нутгийн санхүүжилтээр 116,067.5 мянган төгрөг нийт 906,750.5 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 833,058.0 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 70,878.4 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 116,067.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 98.3 хувь буюу 114,180.4 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 1,887.1 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	1,695,4	1,695,4	0.00	100.00%
2	80312 Сургалт семинар	847,7	847,7	0.00	100.00%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,695,4	1,695,4	0.00	100.00%
4	81801 Үдийн цай хөтөлбөр	38,443,7	32,250,0	6,193,7	83.89%
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	59,778,3	52,323,7	7,454,5	87.53%
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	17,981,1	17,981,1	0.00	100.00%
7	81823 Боловсролын байгууллагын багш	3,814,7	3,814,7	0.00	100.00%
8	<b>81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр</b>	4,829,9	2,520,9	2,309,0	52.19%
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	569,068,5	533,602,2	35,466,2	93.77%
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	89,848,6	70,782,2	19,066,4	78.78%
11	81848 Сурах бичгийн түрээс	2,539,7	1,224,2	1,315,5	48.20%
12	80112 Нийтлэг үйлчилгээ	116,067,5	114,180,4	1,887,1	98.37%
13	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын төлбөр	140,0	140,0	0.00	100.00%
	<b>ДҮН</b>	<b>906,750,5</b>	<b>833,058,0</b>	<b>73,692,4</b>	<b>91.87%</b>

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 38,433.7 мянган төгрөгийн батлагдаж 1 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр Бадрах азийн гэгээ ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 32,250.0 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 32,533.2 мянган төгрөг батлагдаж төсөвт 1 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр Бадрах азийн гэгээ ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 32,212.0 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 13,340.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.


Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 869,946.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,049.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар



буюу 9,876.9 мянган төгрөгөөр тогтоосон гүйцэтгэлийн түвшинд материаллаг байдлыг шинэлэх шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 890,946.2 мянган төгрөгийн 22 гүйлгээ, зарлагын 104,252.9 мянган төгрөгийн 10 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 15 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын аудитор Б. Азбаяр гүйцэтгэж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	-	-
Нийт дүн	1		1		

*Эх сурвалж: Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023.05.01-ны өдрийн 25 дугаар албан бичиг*



Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.01-ны өдөр 25 дугаар албан бичгээр ирүүлсэн, албан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллажээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,207.8 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрсэнд албан шаардлага өгөв.

#### 5.1 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Тус сургуулийн захирлын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/34 тоот тушаалаар алба хаагчдад цалингийн сангийн хэмнэлтээс 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал 24,207,8 мянган төгрөг олгосон.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагад энэ хуулийн 44.5.1, 46.3 хамаарахгүй, Засгийн газрын ” 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.3, 4,5, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалын Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журмын 1,1, 1.4, Засгийн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, байгууллагын хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3,3, 3.11 дэх заалтуудыг тус тус зөрчин үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, цаашид хууль, журам зөрчин урамшуулал олгох байдлыг таслан зогсоон албан шаардлага өгөв.


2. Илрүүлэлт: Тус байгууллагын биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй газар нь байгууллагын газар эзэмших 0000076054 дугаартай гэрчилгээний хэмжээнээс 1740 м2-аар дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайланд газрыг бүртгэн зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага өгөв

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил								
Сургуулийн захирлын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/34 тоот тушаалаар алба хаагчдад цалингийн сангийн хэмнэлтээс 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон.	1	24,207.8			1	24,207.8		
Биет бус хөрөнгийн бүртгэлд тусгасан газар нь 0000076054 тоот газар эзэмших, гэрчилгээний хэмжээнээс 1740 м2-аар дутуу зөрүүтэй	1				1			
Нийт дүн	2	24,207.8			2	24,207.8		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 2 сарын 23 өдөр

Дугаар 98/14210573/ГНА/2024  
191/НА-СМА-ТНУЗ.

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаагаар Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 5,253 м2 талбай бүхий газрыг 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 133 дугаар, захирамжаар олгож, газрын нэгдсэн санд бүртгэлтэй байхад байгууллагын санхүүгийн тайланд 6993 м2-аар бүртгэсэн, газрын хэмжээ 1740 м2 зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Байгууллагын санхүүгийн тайланд газрын 1740 м2-ын зөрүүг биет бус

5040188

хөрөнгөнд нэмж бүртгэн зөрчлийг арилган, нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Март, нягтлан бодогч У.Сүхбаатар нарт даалгав<sup>2, 3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ  
НОМГОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР:  О. МАНДАХ

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 2 сарын 23 өдөр

Дугаар 106/1412.10.513/БНА/2024.  
191-НА-СТНА-511213.

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн захирлын “Албан хаагчдад урамшуулал олгох тухай” 2023 оны 12 сарын 28-ны өдрийн А/34 тоот тушаалаар алба хаагчдад цалингийн сангийн хэмнэлтээс 1 сарын үндсэн цалингийн урамшуулалд 24,207,819.00 төгрөг олгосон зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагад энэ хуулийн 44.5.1, 46.3 хамаарахгүй, Засгийн газрын “ 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.3, 4.5, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалын Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журмын 1.1, 1.4, Засгийн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, байгууллагын хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.3, 3.11 дэх заалтуудыг тус тус зөрчин үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,


5040212


зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хуулийн заалтуудыг зөрчин урамшуулал олгосон зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Март, нягтлан бодогч У.Сүхбаатар нарт даалгав<sup>2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР:  О.МАНДАХ



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно